# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 171. | Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 30 | 558 |
| 172. | Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 31 | 558 |
| 173. | Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 32 | 559 |
| 174. | Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 33 | 559 |


## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 175. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай | Дугаар 373 | 560 |
| 176. | Мал хамгаалах сангийн тухай | Дугаар 374 | 577 |
| 177. | Журам батлах тухай | Дугаар 375 | 581 |
| 178. | Гадаадаас 2012 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай | Дугаар 376 | 588 |
| 179. | Үндэсний хороо байгуулах тухай | Дугаар 377 | 591 |

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 02 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 30 | Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсон Батжаргалын Батзоригийг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгчийн, Лувсандашийн Гансүхийг Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 02 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 31 | Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4, 32.6 дахь хэсэгт тус тус заасныг баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Батбайн Мангиликийг Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн, Доржпаламын Сугарыг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус улируулан, Батжаргалын Батзоригийг Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Лувсандашийн Гансүхийг Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Өлзийн Уянгыг Төв аймаг дахь сум дундын хоёрдугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 02 дугаар сарын 15-ны өдөр — Дугаар 32 — Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасныг баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цанжаагийн Үйтүмэнг Сэлэнгэ аймаг дахь сум дундын гуравдугаар шүүхийн шүүгчийн, Бадамрагчаагийн Батболорыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 02 дугаар сарын 15-ны өдөр — Дугаар 33 — Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.1, 58.1.2 дахь заалтыг тус тус баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсон Цанжаагийн Үйтүмэнг Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Бадамрагчаагийн Батболорыг Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас, өөрөө хүсэлт гаргасан Норовын Лхагвадоржийг Хэнтий аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Цэрмаагийн Эрдэнэчулууныг Хэнтий аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — Ц.ЭЛБЭГДОРЖ**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 12 дугаар сарын 28-ны өдөр — Дугаар 373 — Улаанбаатар хот

## Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад дор дурдсан агуулга бүхий 610-670 дахь заалт нэмсүгэй:

**610**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ЮАНЬ УЛСЫН ЦААСАН МӨНГӨ |
| Бүтээлч: | Хубилай хааны зарлигаар. |
| Холбогдох он цаг: | 1287 он |
| Хадгалагдаж буй газар: | Монголын Үндэсний музей |
| Дурсгалын шинж байдал: | Модны холтос, зарим ургамлын навч зэргийг хольж тусгай аргаар боловсруулсан цаасан дээр монголын дөрвөлжин бичиг ба хятад бичгээр бичээсийг барлаж, хааны сангийн тамгыг даржээ. Урт: 28 см, Өргөн: 23.5см |
| Хувийн дугаар: | ү.2011.2.1 |

**611**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ЧИНГИС ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Газни хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1221 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Аугаа их Чингис хаан” (Ал-Адл, Ал-Азм, Чингиз Кан) Ар талд: Аббасидын Багдад дахь Халиф Насирын нэр цолыг бичжээ. Голч: 15 мм, жин: 3.1 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.6.124 |

**612**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ӨГЭДЭЙ ХААНЫ ҮЕИЙН АЛТАН ЗООС |
| Бүтээлч: | Тодорхойгүй |
| Холбогдох он цаг: | 1230 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Бичээс гүйцэд тогтоогдоогүй, хамгийн доод мөрөнд энэ зоосыг дэлдүүлсэн Хар Хорум хотын нэрийг Хорм (Хорум) хэмээн монгол үсгээр бичжээ.<br>Ар талд: Исламын болон Халиф Насирын нэрийг бичсэн байна.<br>Голч: 24.1 мм, жин: 4.43 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.688 |

**613**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ӨГЭДЭЙ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Имил хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1241 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Тэнгэрийн хүчин дор” гэж бичсэн. Баруун захад нь Өгэдэй хааны дэгэрэ тамга сийлжээ.<br>Ар талд: “Имил” гэж бичсэн байх ба доод талд “Ал Имал/Ал азам-аугаа их эзэн” гэсэн бичигтэй.<br>Голч: 18 мм, жин: 2.2 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.689 |

**614**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ӨГЭДЭЙ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Хархорум хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1237-1238 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Зүүн талд дэгэрэ тамгатай. Гол дунд “Аллах” хэмээн арабаар бичсэн, түүний доор монгол үсгээр хөндлөнгөөр “Хорм” гэж бичсэн.<br>Ар талд: Дээд талд арабаар “Кх-Р Кхор-М” гэсэн нь “Хархорум” гэсэн үг. Гол дунд арабаар “Ал Имал/Ал Азм” хэмээн бичсэнийг хөрвүүлбэл “Их эзэн” гэсэн үгтэй.<br>Голч: 18 мм, жин: 1.2 гр |
| Хувийн дугаар: | ү.2010.9.71 |

**615**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ӨГЭДЭЙ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Хархорум хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | XIII-XIY зуун |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Зүүн талд дэгэрэ тамгатай. Гол дунд “Аллах” хэмээн арабаар бичсэн, түүний дор монгол үсгээр хөндлөнгөөр “Хорм” гэж бичсэн.<br>Ар талд: Дээд талд арабаар “Кх-Р Кхор-М” буюу “Хархорум” гэсэн үгтэй. Гол дунд арабаар “Ал Имал/Ал Азм” хэмээн бичсэнийг хөрвүүлбэл “Их эзэн” гэсэн үг.<br>Голч: 16 мм, жин: 1.385 гр |
| Хувийн дугаар: | ү.2010.10.72 |

**616**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ӨГЭДЭЙ ХААНЫ ЗЭС ЗООС |
| Бүтээлч: | Самарканд хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1233 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Дээд талд Өгэдэй хааны дэгэрэ тамгатай, тамганы дор уг зоосны бичээсийн эхний хэсэг болох “Самаркандад гүйх энэ зоосыг” гэсэн үгийг бичжээ.<br>Ар талд: Бичээсийн хоёр дахь хэсэг болох “үл хэрэгссэн хэн боловч гэмт хэрэгтэнд тооцогдоно” гэсэн үгтэй. Нүүрэн талд дэлдүүлсэн оныг бичсэн.<br>Голч: 37.5 мм, жин: 5.8 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.690 |

**617**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ГҮЮГ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Хархорум хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1246-1248 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Аллах” гэдэг үгийн дунд холбоо Онгин тамга байх ба түүний дор хөндлөнгөөр “Хорм” хэмээн монгол бичгээр бичжээ.<br>Ар талд: Хоёр мөр араб бичээс “Ал Орду/Ал Азам” гэснийг хөрвүүлбэл “Их орд” гэсэн үг.<br>Голч: 20 мм, жин: 3.5 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.03.02 |

**618**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | МӨНХ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Имил хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1261 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Давхар онгин хүрээнд хоёр тийш харсан сэрээ тамгатай.<br>Ар талд: Имил хотод дэлдүүлэв гэжээ.<br>Голч: 19 мм, жин: 1.36 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.691 |

**619**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ИХ ХААНЫ ЗЭС ЗООС |
| Бүтээлч: | Хорезмын Отрар хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1260 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Хамгийн дээд хэсэгт “хааны мөнгө” гэсэн үг бичээстэй, түүнээс доош Халиф Насирын нэр цол бичигдсэн.<br>Ар талд: Калима.<br>Голч: 42 мм, жин: 7.93 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.692 |

**620**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ӨРГЭНЭ ХАТНЫ ЗЭС ЗООС |
| Бүтээлч: | Алмалык хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1259 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Дээд талд Алмалык гэж бичсэн, дээд ба түүний дор Ал-Адл хэмээн томоор бичжээ.<br>Ар талд: Гол дунд Ал-Азм гэж бичсэн, дээд ба доод талуудад оныг бичсэн.<br>Голч: 28.73 мм, жин: 3.3 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.693 |

**621**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ХАЙДУ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Бухар хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1301 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Бухарын зоос” гэж бичээд Хайду хааны хөндөлтэй дэгэрэ тамгатай.<br>Ар талд: Ал-Малик/Ал-Азам (аугаа их эзэн) гэж бичсэн. |

| | |
|---|---|
| | Голч: 22.5 мм, жин: 2.0 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.694 |

**622**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ХАЙДУ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Канжид хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1303 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Дөрвөлжин хүрээний баруун талд Өгэдэй хааны дэгэрэ тамгатай, зүүн талд нь Цагаадайн овгийн Дувагийн тамгатай.<br>Ар талд: Балархай.<br>Голч: 21.91 мм, жин: 2.7 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.695 |

**623**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ХАЙДУ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Самарканд хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1270-1301 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Дээд талд Хайду хааны хөндөлтэй дэгэрэ тамгатай, тойруулан “Их Имам Самарканд” гэж бичжээ.<br>Ар талд: Калима.<br>Голч: 20.69 мм, жин: 2 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.696 |

**624**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ХАЙДУ ХААНЫ ЗЭС ЗООС |
| Бүтээлч: | Кашкар хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1275 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Дээд талд Хайду хааны хөндөлтэй дэгэрэ тамгатай.<br>Ар талд: Балархай.<br>Голч: 26.98 мм, жин: 1.8 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.697 |

**625**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | БУЯН КҮЛ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Самарканд хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1353 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Аугаа Их Султан Буян Күл хааныг бурхан ивээх |

| | |
|---|---|
| | болтугай, Самарканд" гэсэн араб бичигтэй, Цагаадай удмын Дувагийн тамгатай. |
| | Ар талд: Калима. |
| | Голч: 31 мм, жин: 7.2 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.698 |
| **626** | |
| Дурсгалын нэр: | БУЯН КҮЛ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Базар хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1270-1301 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: "Аугаа Их Султан Буян Күл хааныг бурхан ивээх болтугай" гэсэн бичээстэй. |
| | Ар талд: Калима. |
| | Голч: 22 мм, жин: 2.64 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.699 |
| **627** | |
| Дурсгалын нэр: | МӨНХТӨМӨР ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Булгар хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1267-1280 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Гурвалжин хэлбэртэй цэгэн хүрээнд "Аугаа их хаан Мөнхтөмөр. Булгарт дэлдүүлэв" гэж бичсэн, гол дунд нь баруун хөндөлтэй Бат хааны тамгатай. |
| | Ар талд: Цэгэн гурвалжин хүрээнд "Бурханыг магтагтун" гэсэн араб бичигтэй. Хүрээний гадна талаар "678 он Мухаррам сар" гэж бичсэн. |
| | Голч: 19 мм, жин: 1.17 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.700 |
| **628** | |
| Дурсгалын нэр: | АЛТАН ОРДНЫ ЗЭС ЗООС |
| Бүтээлч: | Тодорхойгүй. |
| Холбогдох он цаг: | 1265-1312 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Гурвалжин хүрээнд Бат хааны овгийн тамгатай. |
| | Ар талд: "Хүтлүг болсон-сайн сайхан болтугай" гэсэн түрэг бичээстэй. |
| | Голч: 15 мм, жин: 1.4 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.701 |

**629**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | АЛТАН ОРДНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Булгар хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1270-1310 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Онгин хүрээнд баруун талдаа хөндөлтэй Бат хааны овгийн тамгатай. Ар талд: Өлзий хээтэй чимэглэлтэй. Голч: 10 мм, жин: 0.23 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.702 |

**630**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | АЛТАН ОРДНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Булгар хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1270-1310 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Баруун талдаа хөндөлтэй Бат хааны овгийн тамгатай. Тамганы 2 талд дэлдүүлсэн гэх үг байх ба дор нь Булгар хотын нэрийг бичжээ. Ар талд: “Вахдаху” гэсэн үгтэй. Голч: 18 мм, жин: 0.92 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.703 |

**631**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ТОГТОХ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Крым хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1299 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Тамга Крымд дэлдүүлэв” гэсэн бичигтэй. Ар талд: “Эрхэм дээдэс Тогтох хаан” гэж бичсэн. Голч: 17.5 мм, жин: 1.4 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.704 |

**632**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ТОГТОХ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Крым хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1307 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Тамга Крымд дэлдүүлэв” гэсэн бичигтэй. Ар талд: “Эрхэм дээдэс Тогтох хаан” гэжээ. Голч: 15.5 мм, жин: 0.87 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.705 |

**633**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ТОГТОХ ХААНЫ ҮЕИЙН ЗЭС ЗООС |
| Бүтээлч: | Крым хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1290-1312 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Тамга Крымд дэлдүүлэв” гэсэн бичигтэй.<br>Ар талд: Цэцгийн дэлбээ хээтэй.<br>Голч: 11 мм, жин: 0.5 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.706 |

**634**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ҮЗБЕК ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Булгар хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1323 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Султан Мухаммад Үзбек хаан” гэсэн бичигтэй.<br>Ар талд: “Тамга Ал Махруса Булгарт дэлдүүлэв. 723 он” гэж бичсэн.<br>Голч: 17 мм, жин: 1.39 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.707 |

**635**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ЖАНИБЕК ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Гулистан хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1351 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Агуу Их Султан Жанибек Дин Мухаммад” гэсэн бичигтэй.<br>Ар талд: “Гулистанд дэлдүүлэв 752” гэжээ.<br>Голч: 15 мм, жин: 1.5 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.708 |

**636**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ЖАНИБЕК ХААНЫ ҮЕИЙН ЗЭС ЗООС |
| Бүтээлч: | Сарай Ал Жадид хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1341-1357 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Хоёр толгойтой бүргэд дүрсэлсэн.<br>Ар талд: “Сарай Ал Жадидад дэлдүүлэв” гэжээ.<br>Голч: 14 мм, жин: 1.7 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.709 |

**637**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ЖАНИБЕК ХААНЫ ҮЕИЙН ЗЭС ЗООС |
| Бүтээлч: | Сарай Ал Жадид хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1352 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Цэцгэн хээтэй<br>Ар талд: “Сарай Ал Жадидад дэлдүүлэв 753” гэсэн араб бичигтэй.<br>Голч: 16 мм, жин: 1.8 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.710 |

**638**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ЖАНИБЕК ХААНЫ ЗЭС ЗООС |
| Бүтээлч: | Сарай Ал Жадид хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1352 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Цэцгэн хээтэй<br>Ар талд: “Сарай Ал Жадидад дэлдүүлэв 753” гэсэн араб бичигтэй.<br>Голч: 17 мм, жин: 1.7 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.711 |

**639**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ХИЗР ХААНЫ ЗЭС ЗООС |
| Бүтээлч: | Сарай Ал Жадид хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1361 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Султан Хизр. Түүнийг Бурхан ивээг” гэсэн бичигтэй.<br>Ар талд: “Сарай Ал Жадидад дэлдүүлэв” гэжээ.<br>Голч: 18 мм, жин: 2.7 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.712 |

**640**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | АБД АЛЛАХ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Их ордод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1368 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Агуу Их Султан Абдаллах Хан. Бурхан түүнийг ивээг” гэсэн бичигтэй. |

| | |
|---|---|
| | Ар талд: "Ордод дэлдүүлэв 770" гэжээ.<br>Голч: 17 мм, жин: 1.5 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.713 |

**641**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | МУХАММАД БУЛАГ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Их ордод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1371 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: "Агуу Их Султан Гияс Ад Дин Мухаммад"<br>Ар талд: "Ордод дэлдүүлэв 773" гэсэн араб бичигтэй.<br>Голч: 18 мм, жин: 2.7 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.714 |

**642**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ДАВЛАТ БЕРДИ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Крымын Каффа хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1424-1437 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: "Онгин хүрээнд алтан ордны удмынхны тамгатай, тойрсон хүрээнд арабаар Султан Давлат Берди хааны нэрийг бичжээ.<br>Ар талд: Дугуй цэгэн хүрээнд Крымын Каффа хотын хаалгаар хийсэн тус хотын сүлдтэй, тойрсон хүрээнд Генеузын захирагч Филлипп Мария Висконтын нэрийг латинаар товчлон бичжээ.<br>Голч: 15 мм, жин: 0.88 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.715 |

**643**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ХҮЛҮГ  ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Мардин хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1267 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: "Хаан Хүлүг Илхан" гэсэн бичигтэй.<br>Ар талд: Дээд талд Хүлүгийн тамгатай, Калима бичсэн.<br>Голч: 25 мм, жин: 2.5 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.716 |

**644**
Дурсгалын нэр: АБАГА ХААНЫ МӨНГӨН ЗООС
Бүтээлч: Табриз хотод дэлдсэн.
Холбогдох он: 1265-1282 он
Хадгалагдаж буй газар: Хархорум музей
Дурсгалын шинж байдал: Нүүрэн талд: “Аугаа Их Хаан” гэсэн бичигтэй.
Ар талд: Калима
Голч: 20 мм, жин: 2.7 гр
Хувийн дугаар: ү.2011.13.717

**645**
Дурсгалын нэр: АХМАД ТЭКҮДАР ХААНЫ ЗООС
Бүтээлч: Табриз хотод дэлдсэн.
Холбогдох он: 1283 он
Хадгалагдаж буй газар: Хархорум музей
Дурсгалын шинж байдал: Нүүрэн талд: “Хааны нэрээр Ахмадын дэлдүүлсэн” гэж хааны нэрийг арабаар бичсэн.
Ар талд: Дээд талд “Табризд дэлдүүлэв”, Калима бичсэн.
Голч: 22 мм, жин: 2.5 гр
Хувийн дугаар: ү.2011.13.718

**646**
Дурсгалын нэр: АРГУН ХААНЫ МӨНГӨН ЗООС
Бүтээлч: Багдад хотод дэлдсэн.
Холбогдох он: 1285 он
Хадгалагдаж буй газар: Хархорум музей
Дурсгалын шинж байдал: Нүүрэн талд: Монгол бичээстэй зоос “Хааны нэрээр Аргуны дэлдүүлсэн” Аргун гэж арабаар бичсэн.
Ар талд: Калима. “Багдадад дэлдүүлэв” гэжээ.
Голч: 20 мм, жин: 2.26 гр
Хувийн дугаар: ү.2011.13.719

**647**
Дурсгалын нэр: АРГУН ХААНЫ МӨНГӨН ЗООС
Бүтээлч: Табриз хотод дэлдсэн.
Холбогдох он: 1280-аад он
Хадгалагдаж буй газар: Хархорум музей
Дурсгалын шинж байдал: Нүүрэн талд: “Хааны нэрээр Аргуны дэлдүүлсэн. Табризд дэлдүүлэв” гэсэн бичигтэй. Доод талд шонхор шувууны дүрстэй.
Ар талд: Калима
Голч: 21 мм, жин: 2.5 гр
Хувийн дугаар: ү.2011.13.720

| | |
|---|---|
| **648** | |
| Дурсгалын нэр: | АРГУН ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Кабушан хотод дэлдсэн. |
| Холбогдох он: | 1284-1291 он |
| Хадгалагдаж буй газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Монгол бичээстэй зоос “Хааны нэрээр Аргуны дэлдүүлсэн” Аргун гэж арабаар бичсэн.<br>Ар талд: Калима. “Кабушанд дэлдүүлэв” гэжээ.<br>Голч: 19 мм, жин: 2.5 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.721 |
| **649** | |
| Дурсгалын нэр: | АРГУН ХААНЫ МӨНГӨН ДИРХАМ |
| Бүтээлч: | Табриз хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1284-1291 он |
| Хадгалагдах газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Хааны нэрээр Аргуны дэлдүүлсэн”. Аргун арабаар бичсэн. Ар талд: “Калима дэлдүүлэв” гэжээ.<br>Голч: 22 мм, жин: 2.5 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.6.125 |
| **650** | |
| Дурсгалын нэр: | ГАЙХАТ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Табриз хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1292 он |
| Хадгалагдах газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Хааны нэрээр Ринчиндоржийн дэлдүүлсэн” гэж монголоор, “Ринчин Доржи” гэж арабаар бичсэн.<br>Ар талд: Калима<br>Голч: 21 мм, жин: 2.5 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.722 |
| **651** | |
| Дурсгалын нэр: | ГАЗАН ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Фарузан хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1301 он |
| Хадгалагдах газар: | Хархорум музей |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: монголоор “Тэнгэрийн хүчүн дор Газаны дэлдүүлсэн”, арабаар “Газан”, дөрвөлжин үсгээр “Ма-Ка-За” (Махмуд Газан гэдэг |

| | |
|---|---|
| | нэрийн товчлол) хэмээн тус тус бичжээ. Ар талд: Калима “Фарузанд дэлдүүлэв.701” гэсэн бичигтэй. Голч: 25 мм, жин: 4.0 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.723 |
| **652** | |
| Дурсгалын нэр: | ГАЗАН ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Багдад хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1301 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: монголоор “Тэнгэрийн хүчүн дор Газаны дэлдүүлсэн”, арабаар “Газан”, дөрвөлжин үсгээр “Ма-Ка-За” (Махмуд Газан гэдэг нэрийн товчлол) хэмээн тус тус бичжээ. Ар талд: Калима “Багдад дэлдүүлэв.701” гэсэн бичигтэй. Голч: 21 мм, жин: 2.1 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.724 |
| **653** | |
| Дурсгалын нэр: | ГАЗАН ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Табриз хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1295-1304 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: монголоор “Тэнгэрийн хүчүн дор Газаны дэлдүүлсэн”, арабаар “Газан”, дөрвөлжин үсгээр “Ма-Ка-За” (Махмуд Газан гэдэг нэрийн товчлол) хэмээн тус тус бичжээ. Ар талд: Калима “Табризд дэлдүүлэв” гэсэн бичигтэй. Голч: 23 мм, жин: 4.3 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.725 |
| **654** | |
| Дурсгалын нэр: | ГАЗАН ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Табриз хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1295-1304 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: монголоор “Тэнгэрийн хүчүн дор Газаны дэлдүүлсэн”, арабаар “Газан”, дөрвөлжин үсгээр “Ма-Ка-За” (Махмуд Газан гэдэг нэрийн товчлол) хэмээн тус тус бичжээ. |

| | |
|---|---|
| | Ар талд: Калима “Табризд дэлдүүлэв” гэсэн бичигтэй.<br>Голч: 20 мм, жин: 2.1 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.6.126 |

**655**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ГАЗАН ХААНЫ ЗЭС ЗООС |
| Бүтээлч: | Тодорхойгүй |
| Холбогдох он цаг: | 1295 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: Баруун тийш харсан арслангийн дүрстэй.<br>Ар талд: “Газан 694” гэсэн бичигтэй.<br>Голч: 15х17 мм, жин: 2.1 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.726 |

**656**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ӨЛЗИЙТ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Савэ хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1304-1316 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Их Багш, Их Султан, Ард түмний хувь заяаг даатгагч, Шашин ертөнцийг аврагч, Бурхны боол Мухаммад Султан Өлзийтийн үед дэлдүүлэв. Бурхан түүнийг ивээх болтугай” Өлзийт Султан монгол бичигтэй.<br>Ар талд: Калима<br>Голч: 24 мм, жин: 3.4 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.727 |

**657**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ӨЛЗИЙТ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Сивас хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1304-1316 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Их Багш, Их Султан, Ард түмний хувь заяаг даатгагч, Шашин ертөнцийг аврагч, Бурхны боол Мухаммад Султан Өлзийтийн үед дэлдүүлэв. Бурхан түүнийг ивээх болтугай” Өлзийт Султан монгол бичигтэй.<br>Ар талд: Калима<br>Голч: 22 мм, жин: 2.4 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.728 |

**658**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ӨЛЗИЙТ ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Табриз хотод дэлдсэн. |

| | |
|---|---|
| Холбогдох он цаг: | 1308 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Аугаа Их Султан Өлзийтийн үед дэлдүүлэв. Бурхан түүнийг ивээх болтугай. 707 он” гэсэн бичигтэй.<br>Ар талд: Калима, “Табризд дэлдүүлэв” гэжээ.<br>Голч: 24 мм, жин: 4.4 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.729 |

**659**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | ӨЛЗИЙТ ХААНЫ ЗЭС ЗООС |
| Бүтээлч: | Мардин хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1316 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Аугаа Их Султан Өлзийтийн үед дэлдүүлэв. Бурхан түүнийг ивээх болтугай” гэсэн бичигтэй.<br>Ар талд: Калима<br>Голч: 18 мм, жин: 2.0 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.730 |

**660**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | АБУСАИД ХААНЫ АЛТАН ЗООС |
| Бүтээлч: | Газрын нэр бaлархай |
| Холбогдох он цаг: | Он балархай |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Аугаа Их Султан Абу Саид Бахадур хааныг тэнгэр ивээх болтугай” гэсэн бичигтэй.<br>Ар талд: Калима<br>Голч: 22 мм, жин: 3.49 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.731 |

**661**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | АБУСАИД ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Табриз хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1334 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Аугаа Их Султан Абу Саид Бахадур хааныг тэнгэр ивээх болтугай” гэсэн бичигтэй.<br>Ар талд: Калима<br>Голч: 20 мм, жин: 3.2 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.732 |

**662**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | АБУСАИД ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Дамган хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1320 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Аугаа Их Султан |

| | |
|---|---|
| | Абу Саид Бахадур хааныг тэнгэр ивээх болтугай" гэсэн бичигтэй.<br>Ар талд: Калима<br>Голч: 29 мм, жин: 9.21 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.733 |

**663**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | АБУСАИД ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Табриз хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1326 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: "Аугаа Их Султан Абу Саид Бахадур хааныг тэнгэр ивээх болтугай. Табризд дэлдүүлэв" гэсэн бичигтэй.<br>Ар талд: Калима<br>Голч: 22 мм, жин: 3.67 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.734 |

**664**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | АБУСАИД ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Табриз хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1325 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: "Аугаа Их Султан Абу Саид Бахадур хааныг тэнгэр ивээх болтугай. Табризд дэлдүүлэв" гэсэн бичигтэй.<br>Ар талд: Калима<br>Голч: 21 мм, жин: 3.56 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.735 |

**665**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | АБУСАИД ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Багдад хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1333 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: "Аугаа Их Султан Абу Саид Бахадур хааныг тэнгэр ивээх болтугай. Багдадад дэлдүүлэв" гэсэн бичигтэй.<br>Ар талд: Күфи бичгээр бичсэн Калима<br>Голч: 18 мм, жин: 2.84 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.736 |

**666**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | АБУСАИД ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Табриз хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1333 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: "Аугаа Их Султан Абу Саид Бахадур хааныг тэнгэр |

| | |
|---|---|
| | ивээх болтугай. Табризд дэлдүүлэв" гэсэн бичигтэй. Ар талд: Күфи бичгээр бичсэн |
| Калима | Голч: 20 мм, жин: 2.8 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.737 |

**667**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | АБУСАИД ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Язд хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1322 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: "Аугаа Их Султан Абу Саид Бахадур хааныг тэнгэр ивээх болтугай" гэсэн бичигтэй. Ар талд: Калима, "Яздад дэлдүүлэв.722" гэжээ. Голч: 24.5 мм, жин: 3.6 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.738 |

**668**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | АБУСАИД ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Мараг хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1322-1324 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: "Аугаа Их Султан Абу Саид Бахадур хааныг тэнгэр ивээх болтугай" гэсэн бичигтэй. Ар талд: Калима, "Марагад дэлдүүлэв" гэжээ. Голч: 21 мм, жин: 3.6 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.739 |

**669**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | МУХАММАД ХААНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Ахлат хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1338 он |
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: "Аугаа Их Султан Мухаммад хааныг тэнгэр ивээх болтугай. Ахлатад дэлдүүлэв" гэсэн бичигтэй. Ар талд: Калима Голч: 19 мм, жин: 2.50 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.740 |

**670**

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | САТИБЕК ХАТНЫ МӨНГӨН ЗООС |
| Бүтээлч: | Хайш хотод дэлдсэн. |
| Холбогдох он цаг: | 1338 он |

| | |
|---|---|
| Дурсгалын шинж байдал: | Нүүрэн талд: “Султан Адл Сатибек Хан Кхаллада Аллаху Мулкаху” гэж арабаар бичжээ.<br>Ар талд: Калима<br>Голч: 17 мм, жин: 1.8 гр |
| Хувийн дугаар: | ү.2011.13.741 |

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,**
**ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД** **Ё.ОТГОНБАЯР**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 12 дугаар сарын 28-ны өдөр — Дугаар 374 — Улаанбаатар хот

**Мал хамгаалах сангийн тухай**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргаж байхаар тогтоосугай.

2.Мал хамгаалах сангийн орон тооны дээд хязгаарыг 12 хүртэл байхаар тогтоосугай.

3.“Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2001 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 246 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,**
**ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД** **Т.БАДАМЖУНАЙ**

Засгийн газрын 2011 оны 374 дүгээр
тогтоолын хавсралт

## МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Мал хамгаалах сан (цаашид “сан” гэх)-гийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Мал хамгаалах сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Аймаг, нийслэл нь мал хамгаалах сантай байж болно.

2.2. Сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулахад хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус 5 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй Удирдах зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) ажиллана.

2.3. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь санхүүгийн болон хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мал эмнэлэг, үржлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөллөөс бүрдэнэ. Зөвлөлийн дарга нь хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн дэд сайд байх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.4. Аймаг, нийслэлийн мал хамгаалах сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийн дарга нь аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч байх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймаг, нийслэлийн Засаг дарга батална.

2.5. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана.

2.6. Зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцож, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлж дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

2.7. Зөвлөл дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.7.1. сангийн тухайн жилийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг баталж, санхүүгийн хагас, бүтэн жилийн тайланг хэлэлцэх;

2.7.2. сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг мал аж ахуйн салбарын бодлого, хөтөлбөрийн зорилттой нийцүүлэх;

2.7.3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан арга хэмжээг санхүүжүүлэхээр зээл олгох, дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох асуудлыг хэлэлцэх;

2.7.4. сангаас олгосон зээл, түүний эргэн төлөлтийн явцад үнэлэлт, дүгнэлт өгч, зээлийг хугацаанд нь төлүүлэх ажлыг эрчимжүүлэх;

2.7.5. сангийн захирлын үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэн холбогдох хууль тогтоомжийн дагуу шагнал, урамшуулал олгох, үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох талаар санал гаргах;

2.8. сангийн захирлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилон, хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж ажиллана.

2.9. Сангийн захирал дараахь эрх, үүрэгтэй байна:

2.9.1. сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих;

2.9.2. холбогдох хууль тогтоомж, энэхүү журам болон Зөвлөлийн шийдвэр, тухайн жилийн үйл ажиллагааны чиглэл, бизнес төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжилтэд нь хяналт тавих;

2.9.3. хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний гаргасан шийдвэрийн дагуу сангийн тухайн жилийн батлагдсан төсвийг зарцуулах;

2.9.4. хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрснөөр арилжааны банк, гадаад, дотоодын хуулийн этгээд, иргэдтэй хууль тогтоомжид заасны дагуу хамтран ажиллах;

2.9.5. сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн эргэн төлөх үйл ажиллагаанд хяналт тавих;

2.9.6. сангийн орлого төвлөрүүлэх, өр авлага барагдуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах;

2.9.7. сангийн бизнес төлөвлөгөө, төсвийн төслийг салбарын бодлого, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудтай уялдуулан боловсруулж хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хуулийн хугацаанд хүргүүлэх;

2.9.8. Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн ажилтныг ажилд томилох, чөлөөлөх;

2.9.9. сангийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах.

Гурав. Сангийн санхүүгийн эх үүсвэр

3.1. Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7.2-т заасан эх үүсвэрээр бүрдүүлнэ.

Дөрөв. Сангийн хөрөнгийг зарцуулах

4.1. Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан зориулалтаар зарцуулна.

4.2. Сангаас иргэн, хуулийн этгээдэд олгох зээлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн төсөл сонгон шалгаруулах замаар олгоно.

4.3. Холбогдох хууль тогтоомжид заасан мал аж ахуйн үйлдвэрлэлд олгох урамшуулал, дэмжлэг, зээл, эргэн төвлөрсөн хөрөнгийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр сангаар дамжуулан олгоно.

4.4. Сангаас зээл, урамшуулал, дэмжлэг, буцалтгүй тусламж олгох болон эргэн төвлөрсөн хөрөнгөөр төсөл хэрэгжүүлэх сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссыг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тухай бүр байгуулж ажиллуулна.

4.5. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр төсөл сонгон шалгаруулан зээл олгох тохиолдолд төсөл хэрэгжүүлэгчийг төсөл сонгон шалгаруулах комисст саналын эрхтэйгээр оролцуулна.

Тав. Санхүүгийн хяналт, шалгалт

5.1. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага жилд 1-ээс доошгүй удаа сангийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт хийнэ.

5.2. Сангийн тухайн жилийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудитын дүгнэлт гаргуулна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 12 дугаар сарын 28-ны өдөр — Дугаар 375 — Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.7, 21.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг 1 дүгээр, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг 2 дугаар, хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 159, “Журам батлах тухай” Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 166 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — С.БАТБОЛД**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД — Т.ГАНДИ**

Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (цаашид “сан” гэх)-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих үйл ажиллагаанд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Сан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

1.3 Сангийн орлогыг төвлөрүүлэх, уг сангаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулан санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хариуцна.

1.4. Сан нь мөнгөн хөрөнгийн сан байх бөгөөд аймаг, нийслэл, дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан (цаашид “дэд сан” гэх)-тай байна.

1.5. Сангийн харилцах дансны 1 болон 2 дугаар гарын үсгийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга болон сан хариуцсан нягтлан бодогч, дэд сангийн харилцах дансны 1 болон 2 дугаар гарын үсгийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга болон нягтлан бодогч тус тус зурна.

Хоёр. Сангийн орлогын эх үүсвэр

2.1. Сангийн хөрөнгө нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1-д заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

2.2. Дэд санд аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0,3 хувиас доошгүй байна.

2.3. Орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, дэд санд төвлөрүүлнэ.

2.4. Гадаад улс, олон улсын байгууллага, дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс аливаа нөхцөл, болзол тавьсан хөрөнгийн эх үүсвэрийг санд оруулахыг хориглоно.

Гурав. Сангийн зарцуулалт

3.1. Сангийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна.

3.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.6, 22.1.7-д заасан эх үүсвэрийг дараахь зориулалтаар зарцуулна:

3.2.1. гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламжийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зориулан олгосон чиглэл, гэрээний дагуу;

3.2.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүй ажлын байрны төлбөрөөс төвлөрүүлсэн хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасны дагуу.

3.3. Аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс дэд санд хуваарилсан хөрөнгийг тухайн орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зориулсан чиглэл, зорилтот арга хэмжээнд зарцуулна.

3.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээний зардлын төрөл, хамрагдах иргэнд тавигдах шалгуурыг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын төрөл, хамрагдах иргэнд тавигдах шалгуурыг Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлөөс баталсан төсөл, хөтөлбөрт заасны дагуу тус тус тодорхойлно.

## Дөрөв. Сангийн орлого, зарлагын төсөв

4.1. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн жилд орон нутагтаа хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, тэдгээрт сан болон дэд сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өмнөх оны 7 дугаар сарын 1-ний дотор хүргүүлнэ.

4.2. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь улсын төсвөөс санд олгох хөрөнгийн хэмжээ болон сангийн орлого, зарлагыг төлөвлөж, жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.3. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь санд жил бүр улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээ болон сангийн орлого, зарлагын жилийн төлөвлөгөөг хянан улсын хэмжээгээр нэгтгэж, Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн саналыг тусган жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.4. Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага сангийн орлого, зарлагыг хянаж жил бүрийн төсвийн төсөлд тусгана.

4.5. Санд тухайн жилд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшинг харгалзан Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал батална.

4.6. Сангийн тухайн жилийн төсвийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн саналыг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.7. Сангийн батлагдсан төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэн аймаг, нийслэл дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын саналыг харгалзан, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална. Энэхүү хуваарийг санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 1 дүгээр сард багтаан хүргүүлж байна.

4.8. Сангийн хагас жилийн болон жилийн төсвийн тайланг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

Тав. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, тайлан

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг хөтлөх, сангаас олгох хөрөнгийн хэмжээг тодорхойлох, тогтоосон хугацаанд олгох, хяналт тавих, зохион байгуулах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гүйцэтгэнэ.

5.2. Сангийн бүртгэл, тайлангийн маягтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дангаар болон холбогдох асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран баталж мөрдүүлнэ.

5.3. Сангийн зарцуулалтад Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналт, Үндэсний аудитын газар, тэдгээрийн харьяа байгууллагууд тус тус эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

5.4. Сангийн үйл ажиллагаанд мэргэшсэн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд жил бүр танилцуулна.

5.5. Сангийн орлого, зарлагын тайланг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 25.1-д заасан хугацаанд гаргана.

5.6. Сан, дэд сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан гэм буруутай албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага тооцно.

Засгийн газрын 2011 оны 375 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ЖИЖИГ ЗЭЭЛ, САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.2, 12.3, 12.4, 12.8.4, 12.9-д заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (цаашид “сан” гэх)-гаас олгох жижиг зээл, зээлийн хүүгийн төлбөр, санхүүгийн дэмжлэг нь өрхийн болон хувиараа хөдөлмөр эрхлэх, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, хоршоо, нөхөрлөл байгуулах, өргөтгөх, үйл ажиллагаагаа тогтвортой хадгалах, ажлын байр шинээр бий болгох боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

1.3. Сангаас жижиг зээл олгох, зээл болон зээлийн хүүгийн төлбөрийг эргэн төлүүлэх үйл ажиллагааг банкаар дамжуулан гүйцэтгэнэ.

### Хоёр. Жижиг зээл олгох

2.1. Жижиг зээл олгох үйл ажиллагаанд малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, бизнес инкубацийн үйлчилгээнд хамрагдсан иргэн, ажил олоход хүндрэлтэй болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн хамрагдана.

2.2. Энэ журмын 1.3-т заасан банкыг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулна. Шалгарсан банктай хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэрээ байгуулж, тухайн жилд төсөвлөгдсөн хөрөнгийг дансанд нь байршуулна.

2.3. Банкинд байршуулсан зээлийн хөрөнгөд аливаа хүү, төлбөр төлөхгүй.

2.4. Жижиг зээл олгох үйл ажиллагаа эрхлэх банк нь дараахь нөхцөлийг хангасан байна:

2.4.1 Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд, заавал байлгах нөөцийн шаардлагыг сүүлийн 10 сарын турш хангасан тухай Монголбанкны дүгнэлт гаргуулсан байх;

2.4.2 зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийг сангийн өмнө хариуцахаа илэрхийлж баталгаа гаргасан байх;

2.4.3. жижиг зээлийн хүүгийн хэмжээ нь тухайн банкны зээлийн хүүгийн доод түвшингээс бага байх бөгөөд гэрээний туршид банкны олгож байгаа хүүгийн доод түвшингээс доогуур байх;

2.4.4. жижиг зээл олгохтой холбогдсон тусгай шаардлагыг хангасан байх.

2.5. Энэ журмын 2.1-д заасан иргэн тухайн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтанд зээл авахыг хүссэн өргөдөл, төслөө гаргана.

2.6. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан нь иргэний хүсэлтийг хүлээн аваад төсөл хэрэгжсэнээр бий болох ажлын байрны тоо, хүссэн зээлийн хэмжээ, төслийн хэрэгжих боломжийг харгалзан зээл олгохыг дэмжих тухай тодорхойлолт гаргаж банкинд хүргүүлнэ. Хэрэв аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь тухайн иргэний зээлийн барьцааны тодорхой хэсэгт баталгаа гаргаж байгаа бол энэ тухай мэдээллийг тодорхойлолтод оруулна. Энэхүү тодорхойлолт нь зээл олгоход шаардагдах баримт бичгийн бүрдэл хэсэг болно. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тодорхойлолт байхгүй бол банк зээл олгохгүй.

2.7. Жижиг зээл олгох эсэх асуудлыг банк шийдвэрлэнэ. Банк зээл олгохоор шийдвэрлэсний дараа зээлдэгч нь тухайн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага эсхүл сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтантай ажлын байр бий болгох, өргөтгөх, тогтвортой хадгалах асуудлаар гэрээ байгуулна.

2.8. Жижиг зээлийг хоёр жил хүртэл хугацаагаар олгоно. Зээлийн дээд хэмжээ нь малчин болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид таван сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд арван сая хүртэл төгрөг байна.

Гурав. Зээлийн хүүгийн төлбөр нөхөн төлөх

3.1. Сангаас зээлийн хүүгийн төлбөр нөхөн төлөх үйл ажиллагаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.7-д заасан ажил олоход хүндрэлтэй иргэн хамрагдана.

3.2. Ажил олоход хүндрэлтэй иргэн материал, түүхий эд, үр, бордоо, мал, тэжээвэр амьтан, тоног төхөөрөмж, багаж, хэрэгслэл зэргийг худалдан авахад зориулж сангаас хоёр сая хүртэл төгрөгийн жижиг зээл авсан бол зээлийн хүүгийн төлбөрийг сангаас нөхөн төлнө.

3.3. Иргэний хүсэлт, зээлийн гэрээ, зээл болон зээлийн хүүгийн төлбөрийг банкинд төлсөн баримт, материал, түүхий эд, үр бордоо, мал, тэжээвэр амьтан, тоног төхөөрөмж, багаж, хэрэгслэл зэргийг худалдан авсан санхүүгийн баримтыг үндэслэн жил бүрийн эхний улиралд багтаан аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас зээлдэгчид зээлийн хүүгийн төлбөрийн тухайн жилд ногдох хэсгийг сангаас нөхөн төлнө.

Дөрөв. Санхүүгийн дэмжлэг олгох

4.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.7, 28.8.2-т заасны дагуу Засгийн газар болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан төсөл, хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг олгоно.

4.2. Энэ журмын 4.1-д заасан санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, олгох нөхцөл, шаардлагыг тухайн төсөл, хөтөлбөрт нарийвчлан тусгана.

Тав. Жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох
үйл ажиллагааг тайлагнах, хяналт тавих

5.1. Сангийн хөрөнгөөс жижиг зээл олгох, зээлийн хүүгийн төлбөрийг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаа (цаашид "үйл ажиллагаа" гэх)-ны хэрэгжилтэд хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний болон аймаг, дүүргийн зөвлөл хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хяналт, шалгалт хийлгэж болно.

5.2. Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна.

5.3. Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон бол дэмжлэгийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

5.4. Санхүүгийн дэмжлэг олгосон албан тушаалтан болон санхүүгийн дэмжлэг авсан иргэн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, эсхүл хууль бусаар ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 33.1.3-т заасны дагуу хариуцлага тооцно.

5.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгосон зээлийн хүүг нөхөн төлсөн талаархи тайланг дараа сарын 3-ны дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараа сарын 5-ны дотор хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 12 дугаар сарын 28-ны өдөр — Дугаар 376 — Улаанбаатар хот

**Гадаадаас 2012 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай**

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн 2012 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг хавсралт ёсоор батлалсугай.

2. Энэхүү тогтоолын хавсралтад заагдаагүй салбарт гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт ажиллагчдын 5 хүртэл хувь, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийн газар, дотоодын төрийн бус байгууллага, хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах хууль ёсны зөвшөөрөл бүхий гадаадын төрийн бус байгууллагад ажиллах гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг нийт ажиллагчдын 30 хүртэл хувь байхаар тус тус тогтоосугай.

3. Энэ тогтоолын хавсралтад заасан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, тендер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — С.БАТБОЛД**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД — Т.ГАНДИ**

Засгийн газрын 2011 оны 376 дугаар
тогтоолын хавсралт

# БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН 2012 ОНД ГАДААДААС АВАХ АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ НИЙТ АЖИЛЛАГЧДЫН ТООНД ЭЗЛЭХ ХУВЬ

| Салбар | Дэд салбар | Бүлэг | Анги | Тодорхойлолт | Дүрмийн сан (сая.төг) | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 50 хүртэл | | | 51-100 | | | 101-500 | | | 501-ээс дээш | | |
| | | | | | Нийт ажиллагчдын тоо | | | | | | | | | | | |
| | | | | | 50 хүртэл | 51-100 | 101-ээс дээш | 50 хүртэл | 51-100 | 101-ээс дээш | 50 хүртэл | 51-100 | 101-ээс дээш | 50 хүртэл | 51-100 | 101-ээс дээш |
| A | | | | ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙН АЖ АХУЙ, ЗАГАС БАРИЛТ, АН АГНУУР | | | | | | | | | | | | |
| | 01 | | | Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, ан агнуур болон түүнд туслах үйл ажиллагаа | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 | 11 | 12 | 13 |
| B | | | | УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ | | | | | | | | | | | | |
| | 06 | | | Түүхий газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлолт | 60 | 70 | 75 | 75 | 75 | 75 | 75 | 75 | 75 | 75 | 75 | 75 |
| | 09 | 099 | 0990 | Уул уурхайн хайгуул, олборлолтын бусад туслах үйл ажиллагаа | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 |
| C | | | | БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ | | | | | | | | | | | | |
| | 10 | | | Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| | 13 | | | Нэхмэлийн үйлдвэрлэл | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| | 20 | | | Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 | 11 | 12 | 13 |
| | 23 | | | Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 5 | 10 | 15 | 10 | 15 | 20 | 15 | 20 | 25 | 20 | 25 | 30 |
| | 24 | | | Металл үйлдвэрлэл | 5 | 5 | 5 | 10 | 10 | 10 | 15 | 15 | 15 | 20 | 20 | 20 |
| | 32 | | | Бусад боловсруулах үйлдвэрлэл | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 | 11 | 12 | 13 |
| D | | | | ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТЫН ХАНГАМЖ | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| E | | | | УСАН ХАНГАМЖ, БОХИР УС, ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ БОЛОН ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| F | | | | БАРИЛГА | | | | | | | | | | | | |
| | 41 | 410 | 4100 | Барилга угсралт | 10 | 15 | 20 | 15 | 20 | 25 | 15 | 20 | 25 | 20 | 25 | 30 |
| | | | | Уул уурхайн барилга угсралт, бусад | 20 | 25 | 30 | 25 | 30 | 35 | 30 | 35 | 40 | 40 | 40 | 40 |
| | | 421 | 4210 | Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа | 20 | 25 | 30 | 25 | 30 | 35 | 30 | 35 | 40 | 35 | 40 | 45 |
| G | | | | БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА, МАШИН, МОТОЦИКЛИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 45 | | | Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| H | | | | ТЭЭВЭР БОЛОН АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| I | | | | БАЙР, СУУЦ БОЛОН ХООЛ ХҮНСЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | | | | | | | | | | | | |
| | 55 | | | Байр, сууцаар хангах үйл ажиллагаа | 5 | 5 | 5 | 10 | 10 | 10 | 15 | 15 | 15 | 20 | 20 | 20 |
| | 56 | | | Хоол ундаар үйлчлэх үйл ажиллагаа | 5 | 5 | 5 | 10 | 10 | 10 | 15 | 15 | 15 | 20 | 20 | 20 |
| M | | | | МЭРГЭЖЛИЙН, ШИНЖЛЭХ УХААН БОЛОН ТЕХНИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА | | | | | | | | | | | | |
| | 72 | | | Шинжлэх ухааны эрдэм шинжилгээ, ололт, судалгааны үйл ажиллагаа | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 |
| N | | | | ЗАХИРГААНЫ БОЛОН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | | | | | | | | | | | | |
| | | 791 | | Аялал, жуулчлалын агентлаг, аяллын операторын үйл ажиллагаа | 10 | 15 | 20 | 15 | 20 | 25 | 20 | 25 | 30 | 25 | 30 | 35 |
| P | 85 | | | БОЛОВСРОЛ | | | | | | | | | | | | |
| | | 851, 852, 854 | | Бага болон бүрэн дунд, бусад боловсрол олгох үйл ажиллагаа | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 |
| | | 853, 8522, 8530 | | Техник мэргэжлийн дунд боловсрол болон дээд боловсрол олгох үйл ажиллагаа | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 |
| Q | | | | ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД БОЛОН НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА | | | | | | | | | | | | |
| | 86 | | | Хүний эрүүл мэндийн үйл ажиллагаа | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| | 87 | | | Оршин суугчдад үзүүлэх халамжийн үйл ажиллагаа | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 |
| R | | | | УРЛАГ, ҮЗВЭР, ТОГЛООМ НААДАМ | | | | | | | | | | | | |
| | 90 | 900 | 9000 | Бүтээл туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 |
| | 93 | | | Спорт, зугаа цэнгэл, чөлөөт цагийн үйл ажиллагаа | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 |
| S | | | | ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА | | | | | | | | | | | | |
| | 95 | | | Хувийн болон өрхийн хэрэглээний бараа, компьютерийн засвар, үйлчилгээ | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| | 96 | 960 | | Хувийн үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| U | | | | ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА | | | | | | | | | | | | |
| | 99 | 990 | 9900 | Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 |

Жич: 20 хүртэлх монгол ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагад 1 гадаад иргэн байж болно.

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 12 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 377 | Улаанбаатар хот

**Үндэсний хороо байгуулах тухай**

Улсын Их Хурлын 2011 оны 57 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүний хөгжил сангаас 2012 онд иргэнд хишиг, хувь хүртээхтэй холбоотой асуудлаар Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах, хувьцаа эзэмшүүлэх, бэлэн мөнгө олгох ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хороог дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

**Ахлагч** -Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд

**Гишүүд:** -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар;

-Сангийн сайд С.Баярцогт;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди;

-Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт;

-Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан (зөвшилцсөнөөр);

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан;

-Төрийн өмчийн хорооны дарга Д.Сугар;

-Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун;

-“Эрдэнэс-МГЛ” компанийн гүйцэтгэх захирал Б.Энэбиш;

-Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай.

**Нарийн бичгийн дарга:** -Ерөнхий сайдын зөвлөх С.Чинзориг

2. Иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх арга хэмжээний хүрээнд иргэдэд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 1.0 сая төгрөгтэй тэнцэх нэрлэсэн үнэ бүхий хувьцааг эзэмшүүлэх, бэлэн мөнгө олгох асуудлаар шийдвэрийн төсөл боловсруулан 2012 оны 1 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд оруулах, хувьцааны талаархи иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хувьцаа, үнэт цаасны арилжааны чиглэлээр сургалт, сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Үндэсний хороо (С.Батболд)-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД С.БАТБОЛД**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,**
**ХӨДӨЛМӨРИЙН САЙД Т.ГАНДИ**

**Хаяг:**
“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420, 329612
Хэвлэлийн хуудас: 2.25
**Индекс: 14003**